



САНАЛ БОДЛО, ЭРТЭЦҮҮЛЭЛ

Офицер, хилчдийн харилцааны ур чадвар.

Хүн төрөлхтөн өөрөө, сансар огторгуй холын гариг ертөнцөд, газрын гүн рүү арав өнгөрч тоологдох миль-д, түүх палентологиор олон сая жилийн өмнөдөд, эсийн шинжлэх ухаанаар “Хүн” бүтээхэд ойртож очсон боловч антропологи болоод сэтгэл судлалаар бүр ч гайхмаар хэмжээнд хүрээгүй байгаа нь үнэн билээ.

Энэ бяцхан өгүүлийг бичигч би сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх чиглэлийн мэргжилтэн биш ч хил хамгаалалт, улс орны аюулгүй байдлын ажилтнуудыг бэлтгэх хилийн цэргийн дээд сургуулийн багшийн хувьд харилцааны ур чадварын тухай асуудлаар үг дуугарах боломжтой гэж үзсэн юм.

Нийгмийн хүрээний бүх харилцаа хүнтэй л холбоотой. Хүн бол хөдөлмөр, танин мэдэхүй, харилцаа гэсэн гурван төрлийн үйл ажиллагааны субъект мөн. Хүн чухамхүү тэр харилцаанд оролцохдоо хэл, сэтгэхүй нь зонхилох байр суурьтай. Ийм учраас монгол гүн ухаанаар “Хүн хэлээрээ” гэдэг маш ухаалаг үг эртнээс бий болжээ.

Бүхэл бүтэн Европыг өсгөж горниулсан Ромчууд мянга найман зуу гаруй жилийн өмнө Хилийн Цэргийг байгуулсан нь Эртний Монголын Их Нирун улс Хилийн цэргийг тусгайлан бий болсонтой нэгэн үе давхацдаг юм. Энэ байдлаас үзсэн ч бид Хилийн цэргийн талаар, офицер хилчдийг сурган боловсруулах талаар бусдаас ухаан горьдоод байх улс бас ч биш билээ. Хил хамгаалалтын ажиллагааны тасралтгүй үргэлжлэх явцад гарах алдаа дутагдлууд өнөөдөр ч бага бус байсаар байна. гэтэл мэргэшсэн, өөрийнхсөн, зүрх сэтгэлээ өгсөн энэ ажилд минь амь бөх зууралдах алдаа дутагдлууд бараг 100% офицер, хилчдийн харилцааны ур чадвараас

ХИЛ СУДЛАЛ

шалтгаантай байна. Хилийг хүссэн ямар ч түвшинд ямар ч хүч хэрэгслээр хамгаалах тэр бүгд хилчин хүнээс ангид байхгүй.

1. Офицрийн ажлын онцлог, ур чадвар

Хилчин офицер нь хилчдэд шинжлэх ухааны мэдлэг олгох, тэднийг хөгжүүлэх, амьдрах ухаанд сургах үүрэгтэй байдаг. Офицер бүхэн сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлал, даргалах гол үндэслэл зарчмуудыг бүтээлчээр эзэмшсэн байх ёстой. Ерөнхийн цэргийн хэргийн мэдлэг чадвар, хил хамгаалах урлаг дадлагыг биширмээр эзэмшсэн дарга л хэзээ ч үлгэр дууриал болж байдаг нь ойлгомжтой.

Иймээс хилчин офицер аливаа сургалтыг явуулахдаа хилчин нэг бүрд хүрэх дэвшилтэт арга, үйлийг оновчтой сонгон хилийг хамгаалах болоод амьдрах чадварыг төлөвшүүлж хөгжүүлэхийн гадна тэдэнд хүний эрхэм чанараар ухааран мэдэх, биеэ дайчлан суралцах дадал эзэмшүүлэхийг ямагт эрмэлзэн ажиллах нь дүрэмдэгч хүчирхийлэгч дарамтлагчаас өөрийгөө ялган харуулах гол үзүүлэлт мөн. Энэ бол өөрөө ёс суртахууны байр суурьтай буянт үйл юм.

Буянт үйлийн тухай А.В.Суворов тодорхойлохдоо “Цэрэг урам зоригтой офицер баатарлаг зоригтой, генерал эрэлхэг зоригтой байыг хэлнэ” гэсэн байдаг. Хилчдийг боловсруулан сургахад офицрийн нэр хүнд чухал шийдвэрлэх зүйл байх тул офицер өөртөө байнгад хяналт тавьж өөрөө өөрийгөө хөгжүүлж байх учиртай болдог юм.

Офицер нь хилчдийнхээ хүсэл эрмэлзлэл суралцах төлөвших үерхэл нөхөрлөл эрүүл мэнд соёл ёс суртахуун зэрэг тухайн хүнийх нь онцлогоос гадна тасаг, застав, отряд бүлэг хамт олны сонирхол, аж байдал, хүсэл эрмэлзлийг судалж ажиллахгүй бол орчин үеийн хүрээн дэх хил хамгаалалтын үйл ажиллагаанд амжилт олохгүй.

Офицер өөрөө орчин үеийн шинжлэх ухааны олоотоос хилчдийг сургах боловсруулах ажилдаа тусгадаг байхын тулд өөрөө өсч байх шаардлагатай.

Хилчдийг сурган боловсруулах эв дүй бол офицерийн мэргэжлийн ур чадварын нэг бүрэлдэхүүн юм. Энэ нь шигшлэх ухаан тухайн хүний чадвар, дадлагаар тодорхойлогдоно. Харин “Чадвар” “дадал” гэсэн ухагдахууныг сэтгэл зүйн талаархи бүтээлүүдээс зарим нэг хэсэг эрдэмтэд судлаачид дадал бол нэлээд дээд зэргийн бүрдэл бүхий үйлдэл гэж үзсэн байх бөгөөд чадварыг үйлдэл эзэмших анхны шатанд тэд хамааруулж бүрэн төлөвшөөгүй дадал зөвхөн түүний төлөвших үе шат гэж үздэг.

Нөгөө хэсэг нь дадлыг бодоход чадвар нь нэлээд дээд зэргийн бүрдэл үйлдэл эзэмших явцын төгсгөлийн шат гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Эдгээрийг Л.Б Ительсон “Субъект мэдлэг дадалдаа тулгуурлан зохицуулах практик болон сэтгэцийн үйлдлийн нарийн тогтолцоо юм” гэсэн байдаг.

Офицер хилчдийн хоорондын харилцааг амжилттай бүтээлч болгох нөхцөл бол бие хүний хувийн сэтгэлзүйн өвөрмөц онцлог, офицерийн чадварыг түүнд хамааруулан ойлгох нь зүйтэй болно. Хилчин офицер нь хил хамгаалх ажилдаа дур сонирхолтой, мэдлэг боловсролоор сайн, өөрийн онцлогийг иж бүрнээр хэрэгжүүлэх (өөрийгөө зориулах) чадвартай, зан байдлаа удирдаж чаддаг, хэл ярианы илэрхийлэл оновчтой, хилчидтэй хэл ярианы болон ярианы бус холбоо тогтоох, эв дадалтай, гярхай ажигламтгай, бүхий л үед биеэ зөв авч явдаг, дуу хоолойны хувьд зөв хуваарилалттай, хүмүүсийн сэтгэл зүйн талаар тодорхой мэдлэгтэй чухам энд үндэслэж бусадтай харьцдаг байвал зохино.

Офицер өөрөө хилчдийн зан төлөвийн онцлог, нөгөөгөөсөө илүү хурц тодорхой чадваруудыг мэдсэнээр харилцааны явцад үүсэх олон зөрчлөөс сэргийлж чадна.

Германы эрдэмтэд К.Леонград бие хүний зан төлөвийн тодорлыг үндэслэл болгосон ангиллаар хүмүүсийг 11 хэв шинжид хуваажээ. Энэ ангиллыг өөртөө болоод бусад зан төлөвийнхөө хурцдаж байгааг хүмүүстэй харьцахдаа чухам юуг анхаарах ёстойг мэддэг байх шаардлага гарч ирнэ.

ХИЛ СУДЛАЛ

Бие хүний сэтгэл зүйн хэв шинжийг шуурхай оношлох шинж тэмдэгүүд

Хэв шинж	Гадаад төрх	Хөдөлгөөн ба байр байдал	Бусадтай харилцах харилцааны онцлог
Эпилептоид	Хэвийн дундаж бие бялдартай хүн маш нямбай хувцаслах хэв затварыг голлodoг.	Хөдөлгөөнтэй, бусад болон өөртөө шаардлагатай шийдвэр түргэн гаргадаг, захирангуй.	Чанга тод яриатай, яриа нь цэгцтэй ойлгомжтой, хүнтэй тохиолдлоор танилцах дургүй, бусад төдий л ойлгомжтой биш, бусдыг гүнзгий танихыг эрмэлздэггүй, сэтгэл хөдлөлийн харилцааг ойлгодоггүй.
Паранойд	Дундаж чанга бие бялдартай идэвхитэй эрчтэй. Моод хөөдөггүй ч тохиромжтой аятайхан хувцасладаг.	Байнга хөдөлж байдаг, өнгөц, гадаад сэтгэлийг биш, зорилго чиглэлийг үйл ажиллагааныхаа удирдлага болгодог, өөрийнхөө зөв гэдэгт эргэлзэхгүй итгэдэг.	Чанга дуутай, түргэн яриатай бусадтай харилцахдаа зөрчилддөг, харилцааг хүмүүстэй холбоо хэлхээг тогтоох хэрэгсэл гэж үздэггүй, харин зорилгодоо хүрэх хэрэгсэл гэж үздэг, харилцаанд нэлээд түрэмгийдүү хандлагатай.
Гипертим	Идэвхитэй хөдөлгөөнтэй чанга бие бялдартай нэг хэв маягаар хувцасладаггүй гаднаас харахад хайнгадуу.	Тогтворгүй байнга гүйж явдаг, хөнгөн шингэн, уян эвсэг, ямар ч ажилд амжилтад хүрдэг, гэвч яриасаг, ажил төрөлдөө систем муутай.	Маш чанга яриатай, яарч сандарч давхцуулж ярьдаг, хурдан сэтгэх учир санаагаа гүйцээж багтааж амждаггүй, дохио зангаа сайтай боловч яарсны улмаас заримдаа үгээ дуусгадаггүй, бусадтай холбоо тогтоохдоо сайн, харилцаанд дуртай, түүний үнэ цэнийг ойлгодог.
Ихсэйд	Гойд чамин хувцаслах мөн ийм янзаар үсээ янзлах дуртай.	Дуу шуугиантай, бусдын анхаарлыг татамтгай, жүжиглэх	Олон хүнтэй харилцах дуртай, өөрийгөө шүтэн бишрэгчтэй харилцааны

	Хувцасны хаяг фирмийн тэмдэгт анхааран сонирхдог. Хувцасны загварыг сонирхон эрхэмлэгч.	чадвартай, бие даасан байдалтай.	хүрээгээ байнга өөрчилж байдаг.
Шизойд	Хувцас хунараа хайш яайш өмсдөг ба тэдгээрийг сонгох сонголт нь орчныхоо хүмүүсийн саналаас шалтгаалдаг.	Хөдөлгөөн ихтэй, хөдөлгөөн нь оновчгүй, замбараагүй учир юм мөргөх, цохих нь олонтой, юманд эвсэг биш, нүүр царайны хөдөлгөөн илрэл бага, бодлогоширонгүй, гутрамтгай царайтай.	Яриа нь эмх цэгц муутай, тасалдамтгай, үгнүүдийн авцалдаа муутай, харилцъя гэсэн хүнээ сонгож харилцааны хүрээ хязгаарлагдмал өөрийг нь хүмүүс ойлгон, холбоотой байгаасай гэж хүсдэг.
Психологид	Туранхай сулавтар байдалтай, чимээгүй үл ажиглагдам хүн. Ямагт цэвэрч нямбай хувцасладаг. Загварыг хэмжээндээ тааруулан мөрддөг. хүмүүсийн анхааралд өргчихвөл зовж аягүйрхдэг.	Юманд эвсэг биш, хөдөлгөөн багатай хөдөлгөөний зохицолдоо эв дүй муутай.	Яриа нь удаан сунжруу, ямагт намуун ярих бөгөөд нийтийн өмнө үг хэлж чаддаггүй, ичимтгий, шинэ харьцаа холбоо үүсэхээс эмээдэг, бусдад сэтгэгдэл төрүүлж чаддаггүй, хувийн элэгсэг дотно харьцаа тогтоохыг эрхэмлэдэг.
Гипотим	Гадаад төрх байдлаараа дээрх хэв шинжийн хүнтэй төстэй, гэхдээ	Болгоомжлонгүй, амьдралын сүүдэртэй тал руу бүхний анхаарлыг	Харилцааг гомдол санал илэрхийлэх хэрэгсэл гэж үздэг, ер нь бусдын мэдээллээр хүмүүсийн гайхлыг төрүүлэх дуртай.

ХИЛ СУДЛАЛ

	цэвэрч нямбайгаараа түүнийг гүйцэхгүй, сэтгэл дундуур очирдсон, тайван биш байдалтай байх нь олонтой.	хандуулан шүүмжлэхийг эрмэлздэг.	
Сензитив	Хувцсаа аятайхан тохируулж өмсдөг. Сайхан сэтгэлтэй, халамжтай хүний дүртэй.	Юмыг урьдчилан харахыг хичээдэг, бусдын үйл хөдөлгөөнийг хянамтгай гүйцэтгэх чадвар сайтай, үнэнч.	Бусадтай харилцах дуртай, харилцах чадвар сайтай.

Эдгээрээс бусад гурван шинж нь өөрийн гэх бие даасан онцлоггүй, өмнөх хэв шинжүүдийн онцлогоос бүрддэг болно.

Офицер нь хилчдийнхээ сэтгэл зүйн онцлогийг бодитой мэдэж ажиллах явдал харилцааг илүү нөлөөтэй болгох, зайлшгүй үндэслэлтэй байдаг.

2.Хилчдийн хэв маягийг танихуй

Зан төлөв, темперамент, хүмүүжлийн онцлогоосоо шалтгаалан хилчдийн харилцах хэв маяг нь харилцан адилгүй байдаг. Тэдгээрийг ялгаатай байдлаар нь дараахи ангиллаар хувааж болдог.

- Харилцаанд ноёлох байр сууринаас оролцогч. Энэ хүрээнд хамаарах хилчид бусадтай харилцахыг хүсэхээс бус харилцааных нь зорилго эв дүйг тэгтлээ голдоггүй. бусдын тавьсан асуудлыг төдий л чухал биш гэж үзэх бөгөөд бусад нөлөөлөх, харилцааны идэвхийг гартаа авах, харилцагчийнхаа идэвхийг дарж боогдуулахыг эрхэмлэнэ. Харц дохио, зангаа байр байдал нь иймэрхүү шинжийг илтгэх бөгөөд бусадтай харилцахдаа дуугаа өндөрсгөн огцом дуугарч цаад хүнийхээ яриаг таслан нэг ярьсан зүйлээ давтах нь олонтой.

Иймэрхүү хилчидтэй офицер харилцахдаа түүнд таарах боломжийг ашиглахын дээр хатуу байр сууринаас соёлгүй байр сууринаас няцаах хэрэггүй.

- Харилцаанд үл ноёлох байр сууринаас хандагч. Түрүүчийнхээ эсрэг байр суурыг баримтлан харьцагч харилцаанд хүсэмжилсэн байдалтай оролцох бөгөөд харилцааны санаачлагыг гартаа авах, өөрийн үзэл бодлыг илэрхийлэх, асуулт тавих зэргээс ямагт эмээдэг. Энэ хүрээнд хамаарах хилчид харилцан ярилцагчдынхаа оюун ухаан, сэтгэл хөдлөлийн байдал, хүч чадалд маш мэдрэмтгий хандах бөгөөд бусдын яриаг тасалж чаддаггүй, найр тавимтгай, амархан сандарамтгай атлаа өөрийнх нь яриаг бусад хүмүүс тасалж байхад тэвчээр тэй ханддаг, санаа бодло илэрхийлэхдээ шийдвэртэй биш тул санаснаасаа няцан өөрийгөө буруутгамтгай зантай байх агаад үүнийхээ эцэст харамсан сэтгэлээр унах нь цөөнгүй. Хилчин түүний дотор хугацаат албаны хилчин сэтгэлээр унах явдал ямар аюулд хүргэж болох нь ойлгомжтой. Ийм хилчидтэй офицер харилцахдаа хөхүүлэн дэмжиж өөртөө итгэх итгэлийг нь сайжруулан санасан бодсоноо чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгох хэрэгтэй.

- Харилцаанд шуурхай оролцогч. Энэ хэв шинжийн хилчид нь анхаарлын шилжилт сайн, түргэн сэтгэлгээтэй, харилцанд төвөггүй тататгдан ордог, түргэн яаруу яриатай, нэг хэлц өгүүлэмж нь нөгөөгөөрөө солигдох нь хялбархан, түргэн шуурхай байдлаараа харилцан ярилцагчийнхаа ярианы темпийг аяндаа түргэтгэх нөлөөтэй. Хүний яриаг тасламтгай, бусдын ярьж буй зүйлын талаар өөрийн бодлоо идэвхитэй илэрхийлдэг, гэвч санаа бодлоо илэрхийлэх нь цэгцтэй биш, олон янзаар хувирган өөрчлөх сонирхолтой тул гүн гүнзгий шинжилгээ хийхэд чиглэгдсэн удаан хугацааны харилцаанд оролцуулахад төвөгтэй байдаг. Иймэрхүү хилчинтэй хийх офицерийн яриа эхлээд ярианы темпенд нь тохируулах, түргэн явагдах, аажмаар темпийг удаашруулан санаачлагыг гартаа вах болдог. Тэгээд ярианы агуулгыг эргүүлэн тодруулах шаардлагатай юм.

- Харилцаанд яарамгүй оролцогч. Энэ хүрээний хилчид харилцаанд шууд оролцдоггүй, ярилцагчдаа нухацтай судлан, санаа бодлыг нь мэдэхийг хичээдэг.

Ямар нэг талаар даргалагчаа офицероо чамалах хандлага зарим үед дотоодод нь бий болдог. Үг бүрээ сайтар сонгон санаа

ХИЛ СУДЛАЛ

бодлоо оновчтой төвлөрүүлж яаралгүй ярьдаг. Яриаг нь таслахад дургүй, бусдын санаа бодлыг хэлүүлэх гэж яаравчилдаггүй. Энэ байдлаараа офицероос тэвчээр болоод нэлээд зүйлийг шаарддаг.

- Харилцааны эксераверт субъект. Эксераверт хилчид бусадтай санал бодлоо солилцох хэрэгцээ маш ихтэй тул ярьж харилцана гэдэг тэдний урлаг юм. Бусдыг ойлгох чадвар сайтай, сонинчхан, хүмүүстэй анхааралтай ханддаг. Мөн тийм хандлагыг орчноосоо шаарддаг. /хил хамгаалалт болоод аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны явцад сонинч занд анхаарамжтай хандах шаардлагатай байдаг/. Энэ бүхнийг офицер онцгойлон бодолцох нь чухал.

- Харилцааны интроверт субъект. Энэ хүрээний хилчид сэтгэлийн үйл нь дотогш чиглэсэн олон хүнтэй ярих дургүй, дотор хүнтэйгээ харилцах хандлагатай, гомдомтгой, ичимхий зантай. Офицер ийм байдалтай хилчинд хандах харилцах өөрийн аргыг юуны өмнө олох хэрэгтэй байдаг. Хилийн цэргийн офицер нь дээрхи ангиллын хилчдийн онцлогуудыг байнга харгалзан үзэж чадаж баймааж нь өөрийн болоод затав, отряд, хилийн цэргийг удирдах газар, төр ард түмний хүлээсэн үүргийг бодитой биелүүлэхэд үнэнхүү ач тусаа өгнө. Ер нь зандарган загнагч дүрэмдэн дарамтлагч, /бурхангүй газрын бумба/ гэг байдлаар аашлагч хэн боловч алба ажилд эрт орой хэзээ нэгэн цагт болох хор аюулыг хуримтлуулж байдаг.

Хүний сэтгэл зүй ихэд нарийн юм. Чухам тийм болохын эн түрүүнд харуулагч нь харилцааны илрэлүүд байх бөгөөд тэдгээр нь тухайн хүний хүчин зүйлүүдтэй холбоотой байдаг.

Аливаа хилчин юмс үзэгдэл нөхцөлдүүлэн буй хүчин зүйлүүдийг хэрхэн мэдрэмжлэх вэ гэдгийг нь гагцхүү офицер сайтар мэдэж улмаар зохицуулж чадаж байхын тулд бие хүний сэтгэл зүйн хэв шинжыг шуурхай оношлох шинж тэмдэгүүд болоод (харилцааны хэв маяг)-ыг сайтар судалж өөрийн бишлүүлэх хэрэгтэй болно.

Хил хамгаалалтад шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх ажилтан бүрийн ажиллагааг хилийн харуулд төвлөрүүлэх эрмүүн зорилтод миний бичсэн өгүүлэл бага боловч нэмэр болог.

Багш Л.Сандагсүрэн